

**БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
6 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2021.06.24

НЭГ.ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

2021 оны 6 дугаар сард тус Тамгын газраас нийт :

Явсан бичиг -74

Ирсэн бичиг-23

-хугацаатай бичиг-14

-хугацаандаа явсан-2

-хугацаа болоогүй-12

Тус Тамгын газарт 6 дугаар сард 23 албан бичиг ирснийг удирдлагад танилцуулж, цохолт хийлгэн бүртгэлээр холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.

Тамгын газраас 6 дугаар сард 74 албан бичиг явсан. Явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан.

Хариутай 14 албан бичиг ирсэн. Үүнээс-2 албан бичиг хугацаандаа явсан, хугацаа болоогүй-12 албан бичиг байна. Хариутай бичгийн бүртгэлийг хөтөлж, хяналт тавин ажиллаж байна.

Тайлант сарын байдлаар сумын Засаг даргын “А”захирамж-11, “Б” захирамж-1 Тамгын газрын даргын “А” тушаал-3, “Б” тушаал-11 тус тус гарсан байна.

Байгууллагын архиваас тайлант сард 2 лавлагаа олгож, бүртгэл хөтөлсөн байна.

Сумын Засаг дарга албан болон хувийн ажлаар 20 иргэнийг хүлээн авч уулзан тэдний тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг сонсож ажилласан байна.

Канад сангийн төслийн уралдаанд 1 төсөл хөтөлбөр явуулсан.

Тайлант хугацаанд иргэдэд шаардлагатай багийн Засаг даргын 250 тодорхойлолт гаргаж үйлчилсэн байна.

Төрийн үйлчилгээний оператораас 12-н төрлийн 37 лавлагааг гарган иргэдэд үйлчилсэн. Үүнд:

- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-9
- Нийгмийн даатгалын шимтгэл-7
- Жолооч лавлагаа-5
- Оршин суугаа хаяг -4
- Гэрлэсний лавлагаа-2
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагаа-2
- Шүүхийн шийдвэрийн бусдад өр төлбөргүй эсэх лавлагаа-2
- Вакцины гэрчилгээ-2
- Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх лавлагаа-1
- Иргэний үнэмлэхний лавлагаа-1
- Гэрлээгүй бүртгэлийн лавлагаа-1

Гэрлэлт дуусгавар болсны лавлагаа-1

Е-Mongolia цахим мэдээллийг интернет цахим орчинд сурталчлах хүрээнд нийт 300 гаруй иргэдэд мэдээллийг хүргэлээ.

- Нийгмийн даатгалын дэвтэр цахимаар, НДШ төлөлтөө e-mongolia авах боломж
- Ковид-19 цар тахлын эсрэг вакцины дархлаажуулалт нэмэлтээр хийгдэх зохицуулалт
- Боловсролын үнэлгээний төв элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчийн мэдээлэл e-mongolia-аас харах
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа
- Шүүхийн шийдвэрийн өр төлбөргүй лавлагаа
- Төрийн үйлчилгээг гар утаснаас видео бичлэг
- Оршин суугаа хаягийн тодорхойлолт
- Авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн лавлагаа заавар г.м

Баруун-Урт сумын багийн ажлын албанаас багийн Facebook Page хуудсаар багийн иргэддээ мэдээ мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. Үүнд:

- Ковид-19 цар тахал орон нутагт гарсантай холбоотой цаг үеийн мэдээ мэдээлэл
- 16-17 насны иргэдийн вакцин хийгдэх хуваарь газрын талаарх мэдээлэл

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэх ажлын санал асуулгыг иргэдээс тогтмол авч ажилласан.

2022 оны ОНХС-ийн цахим санал асуулгыг 102 иргэн, цаасаар 1677 иргэнээс авсан.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан БИНХ-ын тэргүүлэгчдийн хурлаар эрэмблэгдсэн жагсаалтыг хэлэлцэн батлуулсан.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Шаргын модод ХХК-ны тарьсан Боловсрол хороололд 400м, Нарлаг хороололд 300 м газрыг нийт 700 м газрыг хашиж хамгаалсан.

“Ойжуулалт Хайлааст” ХХК-ны нийлүүлсэн 1400 ш модыг 9-н багийн 237 өрхөд тарааж тариуллаа. Тус компани нь 1937 м 2 зүлэгжүүлсэн ба 3 хэсэг газарт 4-н замын урд хэсэгт 700м², 36а баруун тал, 500м 2, Одконы баруун тал 600м 2 талбайд зүлгийг тарьж хамгаалсан. 40 кг зүлэгний үрийг ЗДТГ-н ойр орчим болон нийтийн эзэмшлийн зам талбайд тарьсан.

Нийтийн эзэмшлийн зам дагуу 4 хэсэг газарт 1200 ш модыг хашиж хамгаалсан.

5-р тойргийн модыг хамгаалах зурвас байгуулах ажилд БОАЖГ, Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги, Ойжуулалт хайлааст ХХК, Шаргын модод ХХК-тай хамтран 5.8 км хамгаалах ажлыг хийсэн.

Нийтийг хамарсан ажлын хүрээнд “Шарилж устгалын” төслийг хэрэгжүүлж ажилгүй 10 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан.

Нохой устгалын ажлыг “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ газар гүйцэтгэж байна. Энэ сард нийт 20 нохой устгасан байна.

Шарилжгүй Баруун-Урт аяны хүрээнд ОНХС-н хөрөнгөөр 15.0 сая.төгрөгийг тусган “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлж нийт 1, 2-аар тойргийн зам дагуу 20000 м2 талбайг цэвэрлэсэн байна.

Аймгийн БОАЖГ-аас эко бохирын цооног 10 ш хийхээр баг тус бүрээс 1 өрхийг сонгож хийж байна. Борооны улирал эхлэж байгаатай холбогдуулан үерийн далангийн хамгаалалтын цэвэрлэгээний ажил хийгдсэн.

27 б,в, 36, 38-н айлын дээвэр засварын тендерийн техникийн тодорхойлолтыг боловсруулж тендер зарлагдсан. 7 дугаар багийн орц засварын ажлыг Уртын гэгээ ОНӨААТҮГ Газар гүйцэтгэж байгаа ба ажлын явц 45%-тай байна. 48-н айлын орон сууцны гадна пасадны тохижилтын ажлын тендер зарлагдсан.

Баруун-Урт сумын 8 дугаар баг хайлааст үүдэнд 22 нэгж талбар бүхий газруудад сумын Засаг даргын захирамжаар дуудлага худалдаа зарлагдаж иргэдэд ил тод нээлттэй цахимаар амжилттай зохион байгуулагдсан.

Коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дуут дохио ажиллуулах, постуудын хуваарь гаргах ажлуудыг зохион байгуулж байна.

9 дүгээр багийн нутаг дэвсгэр дээр эзэнгүй нурсан, унасан хашааг цэгцлэх ажлыг эрчимжүүлэн ажиллахаар багийн нийт нутаг дэвсгэрээр явж унасан 223 хашааг бүртгэлээ.

Хаврын нийтийн цэвэрлэгээ төвийн 8 багийн нутаг дэвсгэрт Баруун-Урт сумын ЗДТГазрын ажилтан, албан хаагчдыг гэр хорооллын гудамж талбайд хуваарилан зохион байгуулалтыг хийж, 05 сарын 29-нээс 06 сарын 06-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ. 6, 9 дүгээр багт портер машинаар 39 рейс хог зөөвөр хийсэн. 1, 2, 3, 4, 5, 7 багийн хог зөөврийг Сүхбаатар тохижилт-Үйлчилгээ ОНӨҮГ хийж гүйцэтгэсэн.

2 дугаар багийн ажлын албанаас санаачлан “Голоо цэвэрлэе-Гоё орчинд амьдрал” уриалгын хүрээнд Баруун голын 900м2 орчим талбайг багийн иргэд,” Өглөөний гайхамшиг” группийн хамт олны хамт цэвэрлэж 1 портер хог хаягдал түүж хог зөөврийг хийсэн.

ГУРАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:


Сумын Засаг даргын 2021 оны А/25 тоот захирамжаар Агропаркийн 1 га талбайд төмс, хүнсний ногооны тариалалтыг эхлүүлж ажилгүй 10 иргэнийг төмс, хүнсний ногоо тариалах дадал хэвшилд сургаж мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна.

Тус онд сумын хэмжээнд 18 аж ахуй нэгж 50 иргэн 30 га-д төмс, 18,7 га-д нарийн ногоо, 10 га-д тэжээлийн ургамал тариалаад байна.

Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 4 иргэн, аж ахуйн нэгжид олгосон. Аж үйлдвэрийн мэдээ, ХАА-3, ХАА-10 мэдээг Статистикийн хэлтэст хугацаанд нь мэдээлсэн.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын болон багийн хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг Аймгийн ГБХЗХГ-тай хамтран Улаанбаатар хотын Үжин төвийн Монголын үндэсний сургагч багшаас 2 өдрийн сургалтыг авлаа.



Тайлант сард Сургууль цэцэрлэгүүдийн захирал эрхлэгч нарын 2 дугаар улиралын үр дүн, 4, 5, 6 дугаар сарын ур чадварын олгох захирамж, Захирал эрхлэгч нарын ээлжийн амралтын захирамжуудыг тус тус гаргалаа.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг энэ жил “НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД- ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН”-ний дор зохион байгууллаа. Сумын Засаг даргын Тамгын газраас хүүхдийн эрхийг хамгаалах энэ өдөр хөгжлийн бэрхшээлтэй нийгэмд өөрийн дуу хоолойгоо бүрэн дүүрэн илэрхийлэх чадваргүй эцэг эх, нийгмийн асрамж халамжид байдаг 98 хүүхэдтэй уулзаж баярыг бэлэг гардууллаа.



Цар тахалтай хэдий ч ЦАХИМААР зохион байгуулж буй "НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД- ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН"-ийн уулзалтад нэгдэж шууд мэдээллийг хүргэж цахим арга хэмжээнд 26-н байгууллага нэгдэж 1260 гаруй хүүхдэд мэдээлэл авлаа.



Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв нь үндэсний хэмжээнд хүүхдэд сэтгэл зүйн болон бусад зөвлөгөө, мэдээлэл өгөх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын шуурхай үйлчилгээг үзүүлдэг болсноос хойш хүүхэд эмэгтэйчүүд хүчирхийллийг таслан зогсоох, өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдээллийг түргэн шуурхай хүргэх 108 утасны мэдээллийг хүүхэд багачуудад таниулах мэдээллийг цахимаар хүргэлээ.



Монголын гэр бүл алдаршуулах төв, Монгол бэрийн үндэсний холбоо, Монголын уран бэрийн үндэсний холбоотой хамтран, гэр бүлийн таатай уур амьсгалыг бүрдүүлэх олон хүүхэд өсгөж байгаа ээжүүдийн үнэ цэнийг сурталчлах, алдаршуулах эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор "Дархан бэр", "Уран бэр" үйл ажиллагааг Баруун-Урт сумын ЗДТГазар 3 дахь жилдээ зохион байгуулж байна. Мөн 3 хүү, төрүүлсэн ээжид "Дархан бэр" 3 охин төрүүлсэн ээжид "Уран бэр" цолыг олгодог бөгөөд энэ жил 25 ээжид эрхэм хүндтэй шагналын эзэд боллоо.



9 дүгээр багийн ажлын албанаас Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан багийн ажлын алба болон аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч нар хамтран олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах боломжгүй тул 30 хүүхдийн гарын бэлгийг гэрт нь хүргэж өгч хүүхдүүдээ баярлууллаа.

ТАВ.ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Дотоод хяналтын нэгжийг Тамгын газрын даргын тушаалаар томилон жилийн ажлын төлөвлөгөө гарган батлуулаад байна.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг сумын ИТХ-ын тогтоолоор томилон, жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцээд байна.

Архины хэрэглээг бууруулах, архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд сурталчлан, таниулах зорилгоор “Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөр боловсруулан сумын ИТХ-аар, 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг гарган сумын Засаг даргаар тус тус батлуулаад ажиллаж байна.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар нь коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Шадар сайдын 2020 оны 3 дугаар сард баталсан Коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журмын дагуу халдвартай бүс нутгаас ирсэн иргэнийг тусгаарлаж, ажиглалтад авах зорилгоор “Иргэнийг түр тусгаарлан ажиглах гэрээ” байгуулан ажиллаж гэрээний үүргээ биелүүлээгүй 10 иргэнийг Сүхбаатар аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид өгөөд байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг боловсруулан бэлтгэж www.baruun-urt.su.gov.mn Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран, олон нийтэд хүргэж байна.

ЗУРГАА.САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Төрийн сан нь төсвийн болон төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, төсвийн хэрэгжилтийг хангах, урсгал хяналтыг гүйцэтгэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

6-р сарын байдлаар орон нутгийн болон төвлөрүүлэн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын 8,566,832.7 мянган төгрөгийн /3876/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн сангийн хувьд 657,291.5 мянга төгрөгийн татварын болон татварын бус орлого орж, татварын орлого төлөвлөгөө нь 81.8 хувьтай байна.

Төрийн сан 18 н байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хянан хүлээн авч, нэгтгэн сумын төсвийн гүйцэтгэлийн өр авлагын мэдээг Freebalance программд оруулсан.

Төлбөр тооцооны өдөр тутмын ажил гүйлгээний баримтуудыг бүрэн бүрдүүлж, НББ-ийн журналтай тулгаж, тухай бүр төрийн сангийн харилцах, кассын мемориалын баримтуудыг үдэж архивын нэгж үүсгэсэн.

2021 онд Орон нутаг хөгжүүлэх сангаар хийгдэж буй ажлын явц гүйцэтгэлийг onhs.mof.gov.mn сайтад тухай бүр мэдээлж байна.

Харьцуулалтын аргаар 2 тендер, шууд худалдан авалтын аргаар 7 ажил тус тус зохион байгуулаад байна. Орон нутгийн хөгжлийн сангийн ажлын гүйцэтгэл 50% буюу нийт 172,162.0 мянган төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Орон нутгийн өмчийн газар, хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн худалдан авалтын тайланг хүргүүлсэн.

2022 онд орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын санлыг иргэдээс авч, эрэмбэлэх, ИНХуралаар хэлэлцэх батлах ажилд арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Сум хөгжүүлэх сангийн хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн хүү болон үндсэн зээлийн төлөлтөд тогтмол хяналт тавин зээлийн төлөлтийн хуваарийг тухай бүр хөтлөн ажиллаж байна.

ЛҮЭ компанитай байгуулсан гэрээний дагуу сум хөгжүүлэх сангийн програмыг суулгаж, зээлдэгч нарын мэдээллийг оруулж байна.

Хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг шүүхэд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна. Сүхбаатар аймаг дахь Төрийн Аудитын газраас сум хөгжүүлэх сангийн 2019-2020 оны баримтуудад төлөвлөгөөт шалгалт хийж, холбогдох бичиг баримтуудыг хүргүүлээд байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Статистикийн мэдээ тайлан гаргалтанд хяналт тавин ажиллаж байна.

2021 оны хагас жилийн мал тооллого ажлыг зохион байгуулан, хяналт тавин ажиллаж байна.

ДОЛОО. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

2021 оны Хяналт шинжилгээ үнэлэгээний ажлын хэсэг байгуулагдан 8 төрлөөр тайланг бэлтгэж байна.

5 тасаг, 55 албан хаагчийн 2021 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 216 дугаар тогтоол, Засгийн газрын эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалын дагуу үнэлэж Төсвийн шууд захирагчид хүргүүлээд байна.

КОРОНА ВИРУСЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

Баруун-Урт-Улаанбаатар чиглэлийн хөдөлгөөнд хяналт тавих, постын өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган ажиллаж байна.

Коронавируст халдвар эрчимтэй нэмэгдэж байгаатай холбогдуулан тусгаарлан ажиглах 7 байрны шаардлагатай бэлэн байдлыг байнга ханган ажиллаж байна. Үүнд:

- Тусгаарлах байранд орох, гарах иргэдийг тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах.
- Тээврийн хэрэгсэл болон тусгаарлах байрны коридор, өрөө бүрийг тухай бүр ӨЭМТөвөөр ариутгал хийлгэж, тогтмол ариутган халдваргүйжүүлж Аймгийн МХГазрын холбогдох мэргэжилтнээр хянуулан ажиллалаа.

- Аюултай хог хаягдлыг Сүхбаатар Хот тохижилт ОНӨГазартай холбогдон тогтмол ачуулах зэрэг ажлыг тус тус зохион байгуулан ажиллаж байна.
- Тусгаарлан ажиглах байранд орсон 208 иргэний судалгааг жагсаалтаар гаргаж, гэрийн ажиглалтад шилжиж байгаа 90 иргэний мэдээлэл, хаяг, утасны дугаарыг нягтлан шалгаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.
- Вакцинжуулалтын мэдээг өдөр бүр гаргаж тайлагнаж байна. 05/02-05/21 хүртэлх хугацаанд Баруун-Урт сумын хэмжээнд 2-р тунгийн дархлаажуулалт 90 хувьтай байна.

Вакцинжуулалтад ажилласан албан хаагчдын ажилласан хоногийн томилолт болон тусгаарлан ажиглах байранд орсон иргэдийн хоол, ор хоногийн төлбөрийг тооцоолон гаргаж, олгуулахаар холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Корона вирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд голомттой бүс нутаг болон Баруун-Урт сумын дам болон ойрын хавьтлын иргэдэд хяналтыг тавьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ойр-508, дам хавьтал-1107, голомтод бүс нутгаас ирсэн-50 иргэн гэрийн ажиглалтанд байна. Гэрийн ажиглалтанд байгаа иргэдийн гэрийн гадна 14 хоног ажиглалтанд байх гэрээс гарахгүй байх зөвлөмж наалтыг 200 айл өрхийн гадна нааж ажилласан.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас хөл хорио тогтоосноос иргэдийн орлого буурч, амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлж байгаатай холбогдуулан иргэн, ААН-ээс нийгмийн хариуцлагын хүрээнд багийн ажлын албатай хамтран дараах тусламж дэмжлэгийг олгосон. 80-аас дээш насны 200 гаруй ахмад настанд Эрдэнэ мандал хийдийн тарьж ургуулсан төмсний дээжээс нэг ахмад настанд 5 кг төмсний тус бүр дэмжлэг үзүүлсэн.

9-р багийн ажлын албанаас Хүүхдүүд “COVID”-ийн эсрэг гар зургийн уралдааныг 1-4 дүгээр анги, 5-8 дугаар анги гэсэн 2 ангиллаар зохион байгуулж, 11 хүүхэд оролцож тус бүрд 2 байр шалгаруулж, дурсамж, гарын бэлгийн хамт гардуулсан.

Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо, Глобал сангийн төслийн хүрээнд Баруун-Урт сумын иргэдэд сурьезгийн тусламж үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх хамтарсан багийн бүрэлдэхүүнийг захирамжаар батлуулан ажилласан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРМАА